



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/67

Бөхт

Шууд гэрээ байгуулах эрх олгох тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 124 дүгээр тогтоол, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны хөрөнгө оруулалтаар хийгдэх “Малын эрүүл мэндийг хамгаалах, эрсдлээс урьдчилан сэргийлэх ажил”-ыг 10,000,000 (арван сая) төгрөгөөр “Бөхт таван эрдэнэ” ХХК-тай шууд гэрээ байгуулсугай.

2. “Малын эрүүл мэндийг хамгаалах, эрсдлээс урьдчилан сэргийлэх ажил”-ыг зайлшгүй шаардлагатай нөхцөл байдал үүссэн тохиолдолд үр дүнтэйгээр зохион байгуулж хэрэгжүүлэхийг “Бөхт таван эрдэнэ”-ны захирал (Б.Цэрэнням)-д даалгасугай.

3. “Бөхт таван эрдэнэ” ХХК-тай шууд гэрээ байгуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Амгаланжаргал)-д, ажлын уялдааг хангаж, гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн (Б.Мядагмаа)-д, Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Х.Уугандорж) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ